



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
Төрийн Өмчит Хувьцаат Компани

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Гууль тогтоомж хэрэгжүүлж ажиллах тухай

Авлигын эсрэг хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, 8 дугаар зүйл, мөн хуулийн Гуравдугаар бүлэг, 23 дугаар зүйл, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан журмын 3.8 дугаар зүйлийн 3.8.3, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/01 дүгээр тушаал, "Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах тухай" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г нэгдүгээр хавсралтаар, "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хуудас"-ны загварыг хоёрдугаар хавсралтаар, "Ашиг сонирхлын мэдэгдэл, тайлбарын бүртгэлийн хуудас"-ны загварыг гуравдугаар хавсралтаар, "Хууль тогтоомжид заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах баталгааны хуудас"-ны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомж, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, тус компанийн зохион байгуулалтын бүтцэд заасан албан тушаалд томилогдох иргэнээс "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хуудас"-ыг бөглүүлж хуульд заасан мэдээллийг гаргуулан авч цахим бүртгэлд оруулж байх, Удирдах болон эрх бүхий албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлэх Баталгааг гаргуулах ажлыг хэвшүүлж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Түвшинжаргал), Эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

3. Хуульд заасан Захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох явцад Захирлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Худалдан авах, сонгон шалгаруулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Ёс зүйн хорооны нарийн бичгийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нар Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргуулан авч эрх бүхий албан тушаалтанд "Ашиг сонирхлын мэдэгдэл, тайлбарын бүртгэлийн хуудас"-аар хүлээлгэн өгч байхыг тус тус даалгасугай.

4. Ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх талаар Гүйцэтгэх захирлын туслах, Ёс зүйн хороо, Төлөөлөн удирдах зөвлөл, Худалдан авах, сонгон шалгаруулах ажлын хэсгийн нарийн бичгийн нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.


5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Р.Бямба нарт тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.БАТСҮХ

1117144653
УХМ0079 5214203



АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ БОЛОН НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ
 СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ,
 “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
 2020-2023 ОН

№	Хийх ажлын төлөвлөгөө	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
1.	Авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах	Байнга	Хууль, эрх зүйн газар
2.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багштай хамтран ажиллах	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, Хууль, эрх зүйн газар
3.	Хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах	2020 оны 01 дүгээр сар	Хууль, эрх зүйн газар, эрх бүхий албан тушаалтан
4.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор	Хууль, эрх зүйн газар Захиргаа, удирдлагын газар
5.	Хөрөнгө, орлогын болон оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх	Тухай бүр	Хууль, эрх зүйн газар, эрх бүхий албан тушаалтан
6.	Авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах	Байнга	Хууль, эрх зүйн газар, эрх бүхий албан тушаалтан
7.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд компанийн мэдүүлэг гаргах албан тушаалтны тухайн оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бүрэн гаргуулж мэдүүлж байх	Хуульд заасан хугацаанд	Эрх бүхий албан тушаалтан
8.	ХАСХОМ шинэчлэн гаргах нэрсийн жагсаалт, тайлан болон тайлант онд шинээр нэмэгдсэн болон хасагдсан мэдүүлэг гаргагчийн мэдээллийг тус тус бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх	Тогтоосон хугацаанд	Эрх бүхий албан тушаалтан
9.	Нийтийн албанд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулах ажлыг компани, охин, хараат компани болон салбар, нэгжид мөрдүүлж хэвших	Тухай бүр	Эрх бүхий албан тушаалтан

10.	Нийтийн албан тушаалтныг ажилд томилох шийдвэрийн үндэслэлд Авлигатай тэмцэх газрын дүгнэлтийг тусгах ажлыг компани, охин, хараат компани болон салбар, нэгжид мөрдүүлж хэвших	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар
11.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	Байнга	Олон нийттэй харилцах, Эрх бүхий албан тушаалтан
12.	Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхэд хяналт тавих зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Ажлын хэсэг, Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нартай хамтран ажиллах	Байнга	Эрх бүхий албан тушаалтан Нарийн бичгийн дарга нар
13.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д баталгааг гаргуулж хэвших	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, эрх бүхий албан тушаалтан
14.	Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай Хууль тогтоомж, Албан даалгавар, зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийн талаарх Тайлан мэдээг Зам, Тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж байх.	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, эрх бүхий албан тушаалтан
Нэг. Нийтлэг асуудал			
1.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулсны дараа албан тушаалд томилох	Байнга	Захиргаа, удирдлагын газар
2.	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг төсөвлөж санхүүжүүлэх	Байнга	Хууль, эрх зүйн газар, Санхүү, эдийн засгийн газар
3.	Тухайн онд шинэчлэн гаргах болон албан тушаалд томилогдсон албан хаагчид хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацааны дотор гаргаж байх үүргийг компанийн хэмжээнд хэвшүүлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, худал мэдүүлсэн албан хаагчид хариуцлага хүлээлгэх;	Тухай бүр	Хууль, эрх зүйн газар, эрх бүхий албан тушаалтан
4.	Авлигатай тэмцэх, түүний нийгмийн хор хөнөөлийг ухуулан таниулах зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжиж хамтарч ажиллах	Байнга	Захиргаа, удирдлагын газар Олон нийттэй харилцах, Эрх бүхий албан тушаалтан
5.	Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Компани өөрөө эсхүл Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчлөх	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, Хууль, эрх зүйн газар
6.	УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2012 оны 05-р тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, Хууль, эрх зүйн газар

	заасны дагуу хуулийн этгээдийн удирдах түвшинд гарах шийдвэр гаргах, албан тушаалтан бараа, ажил үйлчилгээ худалдан авах, сонгон шалгаруулах, гэрээ хэлцэлийн төсөл боловсруулах, хяналт, шалгалт хийх үед Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан мэдэгдлийг гаргуулан авч байх		
7.	Төрийн үйлчилгээний албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх;	Байнга	Захиргаа, удирдлагын газар, Хууль, эрх зүйн газар
8.	Хуулийн этгээдийн удирдах түвшинд гарах шийдвэр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах, сонгон шалгаруулах, гэрээний төсөл боловсруулах болон шийдвэр гаргахад оролцогчдоос Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдлийг гаргуулан авах талаар тухайн тушаал, шийдвэрт тусгайлан тодорхой зааж өгөх	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, Хууль, эрх зүйн газар
9.	Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Ажлын хэсэг, Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нар Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдлийг ажиллагаа дууссаны дараа Эрх бүхий албан тушаалтан бүртгэлээр хүлээлгэн өгч цахим бүртгэлд хамруулах	Тухай бүр	Нарийн бичгийн дарга нар Эрх бүхий албан тушаалтан
Хоёр. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажилтны сонгон шалгаруулалт, томилгоонд мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр			
1.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулж ажиллах;	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, Хууль, эрх зүйн газар
2.	Батлагдсан зохион байгуулалтын бүтцийн орон тоо Ажилтан, албан хаагч бүрийн бүрээр ажил, үүргийг тодорхой болгох, ачааллыг жигдрүүлэх эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж тухайн ажлын байранд хориглох зүйлийг холбогдох хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх	Байнга	Захиргаа, удирдлагын газар, Хууль, эрх зүйн газар
3.	Ажилтны сонгон шалгаруулалтын журмыг нийтэд нээлттэй байлгах, сонгон шалгаруулалтыг компанийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлах	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар
4.	Эрхлэх хүрээний асуудлын тодорхой чиглэлээр шийдвэр гаргахдаа нийтийн эрх, ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй асуудлаар холбогдох мэдээлэл, хэрэгжүүлэх арга зам, хяналтын механизмыг ил тод нээлттэй байлгах	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар
5.	Нийтийн албан тушаалтныг ажилд томилох шийдвэрийн үндэслэлд Авлигатай тэмцэх газрын дүгнэлтийг тусгах		Захиргаа, удирдлагын газар
6.	Удирдах болон эрх бүхий албан тушаалтан, эрсдэл бүхий албан тушаалд ажиллаж байгаа, ажилтан, албан хаагч бүрээр хуульд заасан	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, эрх бүхий албан тушаалтан

	хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах баталгаа, амлалт гаргуулж авч байх		
7.	Албан тушаалд нэр дэвшиж томилогдсон этгээд бүрээр хуульд заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах баталгаа, амлалт гаргуулж авч байх	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар, эрх бүхий албан тушаалтан
8.	Компанийн хүний нөөцийн жагсаалт, түр чөлөөлөгдсөн, сонгон шалгаруулалтад тэнцсэн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй мэдээлдэг болох	Байнга	Захиргаа, удирдлагын газар
9.	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн ажилд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Байнга	Захиргаа, удирдлагын газар
10.	Ажилтан, албан хаагчийн Ёс зүйн дүрмийг зохих журмын дагуу баталж мөрдүүлэх, ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд салбар дээд байгууллага, Авлигатай тэмцэх газраас санал, зөвлөгөө, дэмжлэг авч ажиллах	Тухай бүр	Захиргаа, удирдлагын газар Ёс зүйн хороо
11.	Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, хамт олныг хутган үймүүлсэн, ажлаа цалгардуулсан, ажил үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, гүйцэтгэхээс зайлсхийсэн болон ёс зүйгүй явдалтай холбоотой аливаа дутагдал, доголдол гаргасан ажилтны асуудлыг компанийн "Ёс зүйн хороо"-ны хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргуулж байх	Байнга	Захиргаа, удирдлагын газар
12.	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Байнга	Захиргаа, удирдлагын газар
13.	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, хуулийн хугацаанд нь шуурхай хүлээн авч шийдвэрлэж хариу өгөх, энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Байнга	Захиргаа, удирдлагын газар
Гурав. Компанийн үйл ажиллагааны мэдээллийн нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, ажилтны ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр			
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, компанийн санхүүгийн мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлэх	Тухай бүр	Санхүү, эдийн засгийн газар, Дотоод аудитын ажилтан, ХАА-ны мэргэжилтэн
2.	Цахим хэлбэрээр өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох харилцааг журамласан байх	Тогтоосон хугацаанд	Захиргаа, удирдлагын газар
3.	Төрийн байгууллагын мэдээлэл солилцох цахим сантай компанийн мэдээллийн санг холбох байдлаар мэдээлэл солилцох ажиллагааг шуурхай явуулдаг болох	Тогтоосон хугацаанд	Мэдээлэл технологийн ажилтан

4.	Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Тухай бүр	Дотоод аудитын ажилтан
5.	Худалдан авах ажиллагааны нэгдсэн системд компанийн худалдан авалтын мэдээллийг тухай бүр тогтмол оруулах, худалдан авах ажиллагааг нийтэд нээлттэй ил тод мэдээлэх	Төгтоосон хугацаанд	Дотоод аудитын ажилтан ХАА-ны мэргэжилтэн
6.	Байгууллагын төсвийн орлого, зарлага, хандив, тусламж, түүний хуваарилалтыг нийтэд тогтмол мэдээлж байх,	Төгтоосон хугацаанд	Дотоод аудитын ажилтан
7.	Сонгон шалгаруулалтын төсөл, арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжүүлэх зарчим зэргийг нийтэд ил тод мэдээлж, түүнтэй танилцах боломжоор хангах	Төгтоосон хугацаанд	Дотоод аудитын ажилтан
8.	Компанийн Худалдан авах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ авах	Төгтоосон хугацаанд	Мэдээлэл технологийн ажилтан ХАА-ны мэргэжилтэн
Дөрөв. Сургалт			
1.	Холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах. Үүнд: Авлигын эсрэг хууль тогтоомж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж Захиргааны ерөнхий хууль тогтоомж Зөрчлийн тухай хууль тогтоомж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж	Жилд 2 удаа	Захиргаа, удирдлагын газар, эрх бүхий албан тушаалтан Сургагч багш Төрийн бус байгууллага
2.	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг дараах байдлаар төрөлжүүлж АТГ-тай хамтран зохион байгуулах. Үүнд: 1. Удирдах албан тушаалтны сургалт 2. Охин компаниудын нийтийн албан тушаалтныг сургалтад шинээр хамруулах 3. Дотоод аудит, хяналтын ажилтнууд 4. Авлигад өртөх өндөр эрсдэлтэй бусад албан тушаалтан	Жилийн турш	Захиргаа, удирдлагын газар, Эрх бүхий албан тушаалтан
3.	Бусад сургалт. Үүнд: 1. Худалдан авах ажиллагааны баримт бичгийн боловсруулалт, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын явцад анхаарах асуудлаар АЗ гэрчилгээтэй ажилтнуудын дунд 2. Албан хэрэг хөтлөлт, байгууллага хоорондын мэдээлэл солилцох, нууцын мэдээлэлтэй танилцах, байгууллагын мэдээллийн нууцыг хадгалах асуудлаар нийт ажилтны дунд	Тухай бүрт	Захиргаа, удирдлагын газар Нууцын ажилтан, Архив, бичиг хэрэг Эрх бүхий албан тушаалтан хамтран

-----oO-----

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн
А/08 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙТИЙН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛТАНД НЭР ДЭВШИГЧИЙН ХУУДАС

/Хуулийн этгээдийн нэр/

/Салбар, нэгжийн нэр/

Нэр дэвших албан тушаал

Нэр дэвшигчийн овог, нэр

1. Албан тушаалд томилохын өмнөх ажиллагаа:

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг бөглөж өгөх;

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэлд бүртгэх;

Нэр дэвшигч төрийн албан хаагчийн анкет хавсаргах;

Ажлын байрны тодорхойлолтыг хавсаргах;

Өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа талаар Нэр дэвшигчээс бичгээр гаргасан эсэх;

Танилцуулсан эсэх, танилцуулга хүлээн авсан дээд шатны албан тушаалтны шийдвэр;

Мэдүүлэг хүлээн авсан ;

Огноо:

Огноо:

Огноо:

АТГ-т Мэдүүлгийг хянуулахаар албан бичиг явуулах;

АТГ-аас хариу ирүүлсэн байдал;

Огноо, дугаар:

Албан бичгийн дугаар, огноо:

Нэр дэвшсэн этгээдийг томилсон шийдвэр;

Тушаалын огноо, дугаар:

2. Албан тушаалд томилсоны дараах ажиллагаа:

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

4.1.3 .төрийн өмчит...хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйл.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах

10.3. Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйл. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах.

23.3. Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

Хууль тогтоомжид заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах баталгааг удирдах болон эрх бүхий албан тушаалтнаас гаргах

1. ХАСХОМ гаргагчийг шинээр бүртгэх

2. ХАСХОМ-ыг баталгаажуулах


Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах

8.1. Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

ТАНИЛЦСАН:

АЛБАН ТУШААЛД НЭР ДЭВШИГЧ _____

Огноо: _____



**“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Худалдан авах, сонгон шалгаруулах ажиллагаанд гаргасан
Ашиг сонирхлын мэдэгдэл, тайлбарын бүртгэлийн хуудас**

САНАМЖ:

Нийтийн тушаалтан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэх ... журмын 3.8.3-д заасны дагуу... бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах, шийдвэр гаргахад оролцохдоо Албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан мэдэгдэл гаргана:

№	Шийдвэр гаргах, худалдан авах, сонгон шалгаруулах ажлын нэр, агуулга	Сонгосон журам	Захирлын зөвлөл, Худалдан авах, сонгон шалгаруулах ажлын хэсэг, Ёс зүйн хороо, бусад		Мэдэгдэл, тайлбар гаргасан тоо	Мэдэгдэл, тайлбар гаргаагүй тоо	Ашиг сонирхлын зөрчил үүссэн мэдэгдлийг шийдвэрлэсэн байдал
			Шийдвэрийн огноо, дугаар	Гишүүдийн тоо			
1.							
2.							
3.							

Огноо: _____
Хүлээн авсан мэдэгдлийн тоо: _____


Мэдэгдэл, тайлбарыг хүлээлгэн өгсөн:
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга _____ (_____)

Мэдэгдэл, тайлбар, бүртгэлийг хүлээн авсан:
Хүлээн авсан огноо: _____
Тусгай тэмдэглэл: _____

Эрх бүхий албан тушаалтан _____ (_____)

ТАЙЛБАР: Ажиллагаа дууссан огноог тэмдэглэж, бүртгэлийн хуудсыг мэдэгдлийн талаар Эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж, цахим бүртгэлд оруулна.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн
А/08 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



БАТАЛГААНЫ МАЯГТ

(Хууль тогтоомжид заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах
баталгааг удирдах болон эрх бүхий албан тушаалтнаас гаргах)

20__ он __ сар __ өдөр

/Байгууллагын нэр/
нэр/

/Эцэг /эх/-ийн нэр,

/Салбар, нэгжийн нэр/

/Регистрийн дугаар/

/Албан тушаал/
дугаар/

/томилогдсон огноо, шийдвэрийн

Эрх бүхий албан тушаалтан _____ /эцэг /эх/-ийн нэр/ _____ /нэр/
миний бие

Нэг. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн “Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт” 5 дугаар бүлэгт заасан зүйл, заалт тус тус судалж танилцлаа. Үүнд:

10 дугаар зүйл.
Албаны мэдээллийг
ашиглахтай
холбогдсон хориглолт

10.1. Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.

10¹ дүгээр зүйл.
Оффшор бүсэд банкны
данс эзэмших, хөдлөх,
үл хөдлөх хөрөнгө
өмчлөх, хуулийн
этгээд байгуулахтай
холбогдсон хориглолт

10¹. 1. Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглоно.

11 дүгээр зүйл.
Албан үүргээ
гүйцэтгэхтэй
холбогдсон хориглолт,
хязгаарлалт

11.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал явуулахыг бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа хориглоно.

11.2. Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах,

удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.3. Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны шийдвэр гаргахыг хориглоно.

11.4. Энэ хуулийн 11.3-т заасан захиргааны шийдвэр гаргах хязгаарлалт нь төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан албан тушаалтанд хамаарахгүй.

12 дугаар зүйл.

Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох

12.1. Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

13 дугаар зүйл.

Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт

13.1. Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан хязгаарлалт нь Улсын Их Хурлын гишүүний болон Засгийн газрын гишүүний нийгэмд тустай үйл ажиллагааны сурталчилгаанд оролцоход хамаарахгүй.

14 дүгээр зүйл.

Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт

14.1. Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно.

14.2. Албан тушаалтан албан үүрэгтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно

14.3. Албан тушаалтан дараах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө нийтийн албыг төлөөлж болохгүй:

14.3.1. өөртэй нь хамаарал бүхий этгээдийн өмнө;

14.3.2. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хүртдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө;

14.3.3. албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө.

15 дугаар зүйл.

Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт

15.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно.

15.2. Хууль тогтоомжоор болон Засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авахыг хориглоно.

16 дугаар зүйл.

**Бэлэг авахтай
холбогдсон
хязгаарлалт**

16.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно.

16.9. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.

**17 дугаар зүйл.
Хандив авахтай
холбогдсон
хязгаарлалт**

17.5. Албан тушаалтан дараах тохиолдолд биечлэн, эсхүл бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоно:

17.5.1. хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;

17.5.2. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;

17.5.3. өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд.

18 дугаар зүйл.

**Давхар ажил
эрхлэхтэй холбогдсон
хязгаарлалт**

18.1. Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.

20 дугаар зүйл.

**Аж ахуйн үйл
ажиллагаа
эрхлэхтэй холбогдсон
хориглолт**

20.1. Хуульд өөрөөр заагаагүй бол албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.

20.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.

20.5. Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно

21 дүгээр зүйл.

21.1. Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

**Албан тушаалаас
чөлөөлөгдсөний
дараах хязгаарлалт**

21.1.1. урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;

21.1.2. урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;

21.1.3. урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.

21.3. Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.

**22 дугаар зүйл.
Бусад орлогын
хязгаарлалт**

22.3. Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

22.3.1. шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах;

22.3.2. холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах;

22.3.3. холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах;

22.3.4. холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэх.

**7 дугаар зүйл.
Хориглох зүйл**

7.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:

7.1.1. албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

7.1.2. бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;

7.1.3. албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;

7.1.4. төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;

7.1.5. албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;

7.1.6. албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;

7.1.7. албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;

7.1.8. үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

Хоёр. Хууль тогтоомжид заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах Баталгаар үүгээр гаргаж байна.

Гурав. Миний бие албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Хууль тогтоомжид заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Баталгаа гаргасан, албан тушаалтан:

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Гарын үсэг/

Баталгааг хүлээж авсан, Захирал, удирдлага

/Албан тушаал/

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Гарын үсэг/

Санамж:

Удирдах болон эрх бүхий албан тушаалтан бүрээр хуульд заасан хориглох зүйлс, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах баталгаа, амлалт гаргуулж, гарын үсэг зуруулан хувийг 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын гаүарт албан ёсоор ирүүлнэ.